# Корона-19 вирусын эсрэг вакцин хийлгэх тухай (몽골어)

**<Вакцин хийлгэхээс нэг хоногийн өмнө>**

**01. Корона-19 вакцинжуулалтын талаарх заавар мессежийг шалгах**

⊙ Корона-19 вирусын эсрэг вакцин хийлгэх захиалгын тухай мессежийг хүлээн авсны дараа вакцин хийлгэх газар, цагаа дахин шалгах.

⊙ Хөл хөдөлгөөн ихтэй байж болзошгүй тул вакцин хийлгэх газар руу явах нийтийн тээврийн хэрэгслийн замын маршрутыг урьдчилан шалгах

⊙ Вакцинжуулалтад хамрагдах өдрөө тарилга хийлгэх гарынхаа дээд хэсэг ил гарсан хувцас бэлдэх

**<Вакцин хийлгэх өдөр>**

**02. Гэрээсээ гарахын өмнө**

⊙ Өнөөдрийн биеийн байдлаа шалгана уу. Хэрэв та халуурч байгаа бол вакцин хийлгэхээ хойшлуулах

⊙ Бэлдсэн хувцасаа өмсөж, маскаа зүүгээд вакцин хийлгэхээр явах.

⊙ Вакцин хийлгэх товлосон цагаасаа 30 минутын өмнө очих

**03. Вакцин хийлгэх газарт очсоны дараа**

⊙ Вакцин хийлгэх газраа ирээд иргэний үнэмлэх эсвэл вакцин хийлгэх захиалгын тухай мессежээ үзүүлж, вакцин хийлгэх захиалгаа баталгаажуулах

⊙ Биеийн халуунаа хэмжиж, шалгасны дараа вакцинжуулалтын хүлээлгийн өрөөнд орох.

**04. Тарилгын урьдчилсан хүснэгтийг бөглөх**

⊙ Тарилгын урьдчилсан хүснэгтийг бүрэн гүйцэд бөглөнө

**05. Урьдчилсан үзлэг (Эмчийн зөвлөгөө)**

⊙ Урьдчилсан үзлэг хийх эмчээс зөвлөгөө авна.

⊙ Корона-19 вирусын эсрэг вакцины талаар сонирхсон асуултаа асуух

**06. Вакцин тариулах**

⊙ Вакцинжуулалтын өрөөнд орж Корона-19 вирусын эсрэг вакцин хийлгэнэ.

**07. Ажиглалтын өрөөнд хүлээх**

⊙ Вакцин хйилгэсний дараа таны биед гэнэтийн ямар нэг шинж тэмдэг илэрч болзошгүй учир ажиглалтын өрөөнд 15~30 минут хүлээх

**08. Гэртээ харих**

⊙ Ажиглалтын өрөөнд 15~30 минут хүлээсний дараа аль болох шууд гэртээ харьж, хэтэрхий их хөдлөхгүй байх.

⊙ Хоёр дахь удаагийн вакцин хийлгэх өдрөө хуанли дээр тэмдэглэх.

**09. Гэртээ ирсний дараа**

⊙ Вакцин хийлгэсний дараа доорх шинж тэмдгүүд илэрч болох ба эдгээр шинж тэмдэг нь дархлаа бий болох үед илрэх хариу урвал бөгөөд ихэнхдээ 2-3 хоногийн дотор алга болдог.

| | Ангилал | Тарилга хийсэн газар | Бүх бие |
|---|---|---|---|
| Вакцин хийлгэсний дараа илрэх ерөнхий шинж тэмдэг ба авах арга хэмжээ | Шинж тэмдэг | · Өвдөх<br>· Хавдах | · Халуурах<br>· Ядрах<br>· Жихүүдэс хүрэх<br>· Толгой өвдөх |
| | Авах арга хэмжээ | · Тарилга хийсэн газар цэвэрхэн алчуураар хүйтэн жин тавих<br>· Гарны дасгал хийх, гараа хөдөлгөх | · Шингэн зүйл сайн ууж, амрах<br>· Хөнгөн хувцаслах |
| | | · Халуун бууруулах ·өвдөлт намдаах эм уухад хязгаарлалт байхгүй ч аль болох үрэвслийг намдаах нөлөө үзүүлдэггүй ацетаминофен агуулсан эм уухыг зөвлөж байна. | Вакцин хийлгэхээс өмнө халуун бууруулах ·өвдөлт намдаах эм бэлдэх |

⊙ Ихэнх халуун бууруулах ·өвдөлт намдаах эмэнд шинж тэмдгүүд арилах боловч 2-оос дээш хоног тарилга хийсэн газар хавдах, өвдөх, улайж хавдах зэрэг шинж тэмдэг үргэлжилэн илэрвэл эмчид хандах.

⊙ Хэрэв амьсгал давчдах, ухаан алдах, нүүр хавагнах зэрэг шинж тэмдэг дагалдсан хүнд хэлбэрийн харшлын урвал(анафилакси гэх мэт) илэрвэл даруй 119руу холбогдох эсвэл хамгийн ойр байрлах яаралтай түргэн тусламжийн газарт очно уу

<Орчуулгыг Данүри 1577-1366 хийв>